

ОРЧИН ЦАГИЙН ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГА БА ХАМТЫН АЖИЛЛАГАА

MODERN POLICE AND COLLABORATION

**Б.ЭРДЭНЭБИЛЭГ**

ЦЕГ-ын Судалгаа, дүн шинжилгээний төвийн дарга, цагдаагийн хурандаа
ERDENEBILEG B.

Head of Research and analysis center, National Police Agency, Mongolia,
 Police Colonel

Товч утга: Орчин цагийн цагдаагийн байгууллагыг бэхжүүлэх, алба хаагчдыг чадавхижуулахад цагдаагийн шинжлэх ухааны судлагдахуун болох цагдаа ба олон улсын хамтын ажиллагааны дараах асуудлын хууль зүйн учир холбогдлыг тодорхойлохыг зорьсон байна. Үүнд:

- олон улсын цагдаагийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн үндсийг боловсронгуй болгох чиглэлээр
- инновацийг хууль сахиулах үйл ажиллагаанд өргөнөөр нэвтрүүлэх
- хууль сахиулах тэргүүн туршлагыг үйл ажиллагаандаа ашиглах
- цагдаагийн байгууллагын дотоод аюулгүй байдлыг хангах ажиллагааны туршлага судлах
- цагдаагийн алба хаагчийн мэдлэг, боловсрол, мэргэжлийн ур чадвар, харилцааны соёлыг дээшлүүлэх сургах, дадлагжуулах

Abstract: Following subjects of the police science should be identified and scrutinized for enforcing modern police and capacity building of its personnel, namely:

- Application of the law enforcement innovation in order to create and develop legal environment of policing in accordance with the international up-to-date standards
- The use of desirable law enforcement experiences in our policing
- Studying international experiences of the police internal oversight or control
- Improving education, professional and interpersonal skills of the police officers.

Удиртгал

Монгол Улс дэлхийн хамтын нийгэмлэгийн гишүүн улс болохын хувьд мэдээллийн даяарчлагдсан зуунд хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хангах чиглэлээр хууль сахиулах хамтын ажиллагааг улам бүр идэвхжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Цагдаагийн байгууллагаас хууль сахиулах ажиллагаа явуулахтай холбоотойгоор олон улсын цагдаагийн болон бусад байгууллагатай дараах хамтын ажиллагааг бэхжүүлж байна. Үүнд:

1. Цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээн дэх хамтын ажиллагаа
2. Олон улсын цагдаагийн хөгжлийн жишиг хандлагад цагдаагийн байгууллага, алба хаагчийг чадавхийг нийцүүлэх ажлын хүрээн дэх хамтын ажиллагаа


“Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэхэд тулгамдаж буй асуудал” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлаар цагдаагийн

байгууллагын үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх хүрэн дэх хамтын ажиллагааны зарим асуудлын талаар хэлэлцүүлсэн.

Иймд өнөөдрийн олон улсын эрдэм шинжилгээний хурлаар хэлэлцүүлэх асуудал нь цагдаагийн байгууллага, алба хаагчийн чадавхийг олон улсын жишигт хүргэх хэрэгцээ, шаардлага, тулгарч буй бэрхшээл, тэдгээрийг шийдвэрлэхэд олон улсын хамтын ажиллагааны үнэ цэнийг тодорхойлох болно.

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын статистик түүнд хийсэн дүн шинжилгээ

2002 оны 9 дүгээр сарын нэгний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж байгаа эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомж хэрэгжих явцад Монгол Улсад гэмт хэргийн статистикийн үзүүлэлтийг графикаар үзүүллээ.¹



Статистикийн үзүүлэлт нь хууль эрх зүйн зохицуулалтын алдаа, хийдэл, зөрчил, программчлал, мэдээллийг оруулж байгаа алба хаагчийн мэдлэг, мэргэшлийн ур чадвар, ажлын үр дүнгээс улбаалсан болон хувийн хариуцлага, төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагаанаас шалтгаалсан хүчин зүйлүүд нь мэдээллийн бодит байдалд нөлөөлж харьцангуй тоон үзүүлэлтийг бий болгодог.

Дээрх статистик үзүүлэлтээр 2014 онд 27318 гэмт хэрэг бүртгэгдсний 12585 буюу 46 хувь нь бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцогдвол зохих этгээд тогтоогдоогүй байсан бөгөөд түүний 6949 буюу 55,2 хувийг илрүүлж нийт бүртгэгдсэн хэргийн 7370 буюу 27 хувийг түдгэлзүүлсэн нь мөрдөн шалгах ажиллагааны өнөөгийн үр дүнг илэрхийлж байна.



¹ Дээрх статистик үзүүлэлтээр 2007 оноос гэмт хэргийн илрүүлэлтийг нийт бүртгэгдсэн хэргээс бус харин бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцогдвол зохих хүн тогтоогдоогүй үзүүлэлтээс тооцох болсон байна.

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулахад учирдаг хүндрэл, бэрхшээлийн талаар судалгаанд оролцогчид² өнөөгийн мөрдөн шалгах ажиллагааны дараах тулгамдсан асуудлыг дурджээ.

1. Олон улсын цагдаагийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн үндсийг боловсронгуй болгоход хамтын ажиллагааны гүйцэтгэх үүрэг

“Криминологийн шинжлэх ухаан нь гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд үнэлэлт дүгнэлт зорилгоор цагдааг ялангуяа байгууллагын бүтэц, тогтолцоо, бусад байгууллагатай хамтран ажиллах хэлбэр, алба хаагчдын ёс суртахуун, үйл ажиллагааны арга барил зэргийг 1980-аад оноос судалж эхэлсэн үеэс “Police Science” буюу цагдаагийн шинжлэх ухаан үүссэн гэж үздэг.

Өөрөөр хэлбэл криминологийн шинжлэх ухааны судлах зүйл, судалгааны арга тулгуурлан шүүх эрх мэдлийн болон гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх бодлогыг хэрэгжүүлэх төрийн төв байгууллагаас “цагдаа яагаад хэрэгтэй вэ?” гэсэн асуултанд хариулт өгөх мэдлэгийн цогцыг цагдаагийн шинжлэх ухаан гэж хэлж болно.”³

Нийгмийн сэтгэлгээ ялангуяа шинжлэх ухааныг үзэл сурталжсан байр сууринаас хайрцаглан таниулах нөлөөллөөс улбаалан хууль сахиулах буюу цагдаа судлал дорвитой хөгждөггүй байна.

Орчин үеийн цагдаагийн хөгжилд дараах бодлогууд давхардсан илэрхийллээр зонхилж түүнтэй холбоотой эрх зүйн зохицуулалт, цагдаагийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны хэлбэрээр илэрхийлэгдэж байна.⁴ Үүнд:

Community-oriented policing буюу олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагаа нь цагдаагийн байгууллагын иргэдэд түшиглэсэн, урт хугацаанд олон нийтийн дунд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хянах явцаар хэрэгжих төдийгүй цагдаагийн байгууллагыг олон нийт, бусад холбогдох байгууллага, иргэдтэй холбож хэрэгждэг. Тухайлбал, Хөршийн хяналт, Иргэний зөвлөл гэх мэт.⁵

Нөгөөтэйгүүр олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагаа гэдэг нь гэмт явдал, түүний шалтгаан, нөхцлийг бууруулахад чиглэгдсэн олон нийт болон цагдаагийн байгууллагаас асуудлыг шийдэх арга барилаас улбаалсан үйл ажиллагаандаа баримтлах зарчим юм.

Problem-Oriented Policing буюу асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн цагдаагийн үйл ажиллагаа нь гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх цагдаагийн үйл ажиллагааны (Тухайлбал, хөтөлбөр, төлөвлөгөө) үр дүнд үнэлэлт, дүгнэлт өгч шийдлээ

² Тус судалгааны асуулгад Нийслэлийн цагдаагийн хэлтсүүдийн 513 алба хаагч хамрагдсан байна. Судалгаа, дүн шинжилгээний төвийн тайлан.,2014 он

³ Introduction (Greene 2007). P xix in The encyclopedia of Police Science

⁴ Хүнд болон онц хүнд гэмт хэрэг үйлдэгдэх, түүнийг өдөөх хүчин зүйл, нөхцөл, шалтгааныг олж илрүүлэхэд чиглэсэн цагдаагийн үйл ажиллагаа буюу “**Broken windows policing**”, Бүлэг, бөөгнөрөлд чиглэсэн цагдаагийн үйл ажиллагаа буюу “**Pulling levers policing**”, Гэмт хэрэг үйлдээгүй ч, болзошгүй хүмүүсийг өдөр тутмын амьдарлын үйл ажиллагаанаас өөр зүйлд цаг заваа зарцуулахгүй байхыг нь нэг талаас ятган сэнхэрүүлж, нөгөө талаас тулган шаардах цагдаагийн үйл ажиллагаа буюу “**Third-party policing**”, Гэмт хэрэг ихээр үйлдэгддэг газарт (ялангуяа хот, суурин газарт) анхаарч ажиллах цагдаагийн үйл ажиллагаа буюу “**Hot spots policing**”, Статистик мэдээ, сангийн мэдээлэлд үндэслэгдсэн цагдаагийн үйл ажиллагаа буюу “**Comp-stat policing**” болон Нотлох баримтанд үндэслэсэн цагдаагийн үйл ажиллагаа буюу “**Evidence based policing**” гэх мэт.

⁵ Community-Oriented Policing: Effect and Impact (Greene, 2007. P196 in The encyclopedia of Police Science

тодорхойлох явдал байна.

Энэ нь цагдаагийн үйл ажиллагаанд бэрхшээлтэй асуудлыг тодорхойлох эсвэл аливаа үйл ажиллагааны үр дүнг тооцон тэдгээрт дүн шинжилгээ хийн зохих арга хэмжээ төлөвлөх, хэрэгжилтийн хяналтын тогтолцоог буй болгодог байна. Тухайлбал, тодорхой төрлийн жишээлбэл, садар самуун, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэхэд цагдаагийн үйл ажиллагаа үр дүнтэй байдаг байна.⁶

Zero tolerance policing буюу хууль, тогтоомжыг ягштал биелүүлэх цагдаагийн үйл ажиллагаа нь нэг ч хүнд ял завшуулахгүй байх зарчмыг баримтлан бүхий л зөрчил, гэмт хэргийг алагчилгүй тууштай тэмцэх, шалгах үйл ажиллагааг хэлнэ.⁷

Гэвч цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүрэгт хамааралгүй захиргааны үүргүүдийг хууль тогтоомжоор хүлээлгэж “зеро толеранс” буюу үл тэвчих үзэл баримтлалаар цагдаа “шалгах”, “шийдвэрлэх”, “хянах” эрхтэйгээр ажиллаж ирснээр “цагдаажсан төр” гэсэн ухагдахууныг бий болгодог.

Intelligence-Led Policing буюу мэдээлэлд суурилсан цагдаагийн үйл ажиллагаа нь аливаа халдлага, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, ямар хэлбэрээр хэзээ, хаана үйлдэгдэж болохыг таамаглахын тулд мэдээлэл цуглуулж түүнийгээ бусад хууль сахиулах байгууллагатай хуваалцаж буй үйл ажиллагааг юм.⁸

Дүгнэлт: Монгол Улсын Цагдаагийн албан тухай хуулиар цагдаагийн байгууллага нь үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ олон нийтэд түшиглэсэн (*community-oriented*) тогтолцоог хадгалж улмаар хуулиар харьяалуулсан гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх (*zero tolerance*)-дээ мэдээлэлд суурилсан (*intelligence led*) мэргэшсэн (*problem-oriented*) идэвхтэй үйл ажиллагаатай цагдаагийн байгууллага байх бодлогын үндэс суурь тавигдсан.

Тухайлбал, цагдаагийн байгууллагыг иргэний хяналтад оруулж иргэний зөвлөл байгуулах, олон нийтэд түшиглэсэн, мэдээлэлд суурилсан стратеги үйл ажиллагаа явуулах, нутаг дэвсгэр хариуцсан цагдааг бие дааж хөгжүүлэх, цагдаагийн үйл ажиллагааг тогтоосон стандартын дагуу явуулдаг болох эрх зүйн үндэслэл бүрдсэн билээ.

Цагдаагийн албаны тухай хуульд тусгагдснаар Засгийн газрын 2014 оны 79 дүгээр тогтоолоор “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр”-ийг баталж, улмаар ХЗЯ, ЦЕГ-аас уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангахаар ажиллаж байна. Энэ хөтөлбөрт дараах зорилтыг хэрэгжүүлэхээр тусгагдсан. Үүнд:

- Сайн удирдлага, зохион байгуулалт
- Мэргэшсэн үйл ажиллагаа
- Эрүүл чадварлаг хүний нөөц
- Үр ашигтай төсөв, санхүү, хөрөнгө оруулалт
- Олон нийттэй харилцах

Хууль сахиулах буюу Law enforcement⁹ гэдэг нь хүний эрх, эрх чөлөөг хангах зорилгоор төрөөс тогтоосон эрх зүйн хэм хэмжээг хэрэгжүүлэх, итгүүлэн үнэмшүүлэх, албадлага хэрэглэх, хариуцлага хүлээлгэх эрх бүхий байгууллага, албан тушаалтны эрх, үүргийн үндсэн дээр хэрэгжиж байгаа тодорхой үйл

⁶ Problem-Oriented Policing (Braga, 2007). P1054 in The encyclopedia of Police Science

⁷ Zero Tolerance Policing (Marshall, 1999) http://www.ocsar.sa.gov.au/docs/information_bulletins/IB9.pdf

⁸ Intelligence-Led Policing (Pattavina and Eric Bellone, 2007). P687 in The encyclopedia of Police Science

⁹ http://en.wikipedia.org/wiki/Law_enforcement

ажиллагаа юм.

Хууль сахиулах ажиллагааны судлагдахуун болох criminal investigation буюу мөрдөн шалгах ажиллагааны “inquisitorial”, “accusatorial” эрүүгийн процессуудын онцлогуудыг харьцуулан судлах шаардлагатай.

Тухайлбал, англо саксоны эрх зүйн бүлийн “accustorial” мөрдөн шалгах ажиллагааг явуулах мөрдөгч нь эрх зүйн дүгнэлт хийхгүй бөгөөд гагцхүү мөрдөн шалгах ажиллагааны үр дүнг нотлох баримтын хэмжээнд цуглуулсан эсэхээ шүүхэд гэрчлэх үүрэгтэй.

Энэ ч утгаар мөрдөн шалгах ажиллагаа явуулахдаа нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх, хадгалах, хамгаалах талаархи үйл ажиллагааны стандарт, аргачлалыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгодог нь хүний эрхийг хангах зарчим болжээ.

Цаашдаа “accustorial” мөрдөн шалгах ажиллагааны дэвшилтэт агуулгыг нутагшуулах (рецепци), эрх зүйн конвергенц хийх хандлагатай байгаа хэдий ч өөрийн орны өвөрмөц онцлогыг тусгасан уламжлалт, хэдийнээ хэвшсэн эрх зүйн үнэт зүйлсээ уламжлал болгон хадгалан авч хөгжих шаардлагатай байгааг судлаачид илэрхийлдэг.

Монгол Улсын төрөөс гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх хуулиудын алдаа, коллиз, хийдлийг засах зорилгоор эрүүгийн хууль тогтоомжийн шинэчлэлийг боловсронгуй болгохоор ажиллаж байна.¹⁰

Үүнд хууль сахиулах ажиллагааны олон улсын эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилтийн харьцуулсан судалгаа чухал ач холбогдолтойг дурдах нь зүйтэй.

2. Олон улсын цагдаагийн байгууллагад ашиглаж буй инновацийг хууль сахиулах үйл ажиллагаанд нэвтрүүлэх

Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх ажлыг шинжлэх ухаан, боловсрол, үйлчилгээний нэгдлийг хангахуйц инновацийн үр ашигтай тогтолцоог бий болгон хөгжүүлэх, ялангуяа олон улсын цагдаагийн хууль сахиулах үйл ажиллагаанд нэвтэрсэн шинжлэх ухаан, техникийн ололтыг судалж, худалдан авах, тэдгээрт алба хаагчдыг сургаж, дадлажуулах хэрэгцээ нэгэнт бий болжээ.

Олон улсын цагдаагийн байгууллагуудын үндсэн чиг үүргээ биелүүлэхэд тулгардаг ажлын онцлог ялангуяа бэрхшээл нэг төдийгүй тэд ажил албаараа үргэлж бахархан зүтгэдэг.

Цагдаагийн байгууллагад “Цахим цагдаа” “Цагдаа ба инноваци” зэрэг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд олон улсын төсөл, хөтөлбөрүүдийн тусламж дэмжлэг шаардлагатай байна.

3. Хууль сахиулах тэргүүн туршлагыг хамтран судлах, ашиглах

Цагдаагийн байгууллагын зохион байгуулалтын бүтэц, тэдгээрийн боловсон хүчний бодлого, цагдаагийн ажил үйлчилгээний жишиг нормативийг мөрдөж ажиллах тэр дундаа алба хаагчийн ажлын ачааллыг зүй зохистой хуваарилахад олон улсын жишиг, туршлага нь үнэтэй хувь нэмэр болно.

Тухайлбал, ихэнх улс орны хууль сахиулах байгууллагад амжилттай хэрэгжиж үр дүнгээ өгсөн хууль сахиулах байгууллагын мэдээлэл нэгтгэн боловсруулах тогтолцоо нь шуурхай байдлыг хангаж, улмаар олон салбарын байгууллага нэгэн зорилгоор хамтран ажиллах, цагдаагийн байгууллагын өдөр тутмын ажилд дэмжлэг үзүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр бодит үр дүнд хүрэхэд чухал

¹⁰ Өнөөгийн байдлаар хууль зүйн шинэчлэлийн бодлогын хүрээнд Зөрчлийн, Эрүүгийн материаллаг болон процессын хуулиуд зэрэг 40 орчим хууль батлагдан гарах шаардлагатай гэсэн судалгаа гарсан. Хууль зүйн яамны тайлан 2014 он.

үүрэг гүйцэтгэнэ.

Цагдаагийн албаны үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд хууль сахиулах үйл ажиллагааны стандарт, тактик, арга зүйг орчин үеийн техник хэрэгсэл, шинжлэх ухааны ололт амжилттай хослуулан нэвтрүүлсэн тэргүүн туршлага нэн шаардлагатай байдаг.

Монгол Улсын сүүлийн 3 жилийн статистик мэдээлэлд дүн шинжилгээ хийхэд илрүүлсэн нийт хэргийн 80 орчим хувийг иргэдийн өргөдөл гомдлыг шалгаж шийдвэрлэх явцдаа илрүүлж үлдэх 20 орчим хувийг эрүүгийн тагнуулын ажил болон цагдаагийн алба хаагчдын идэвхтэй үйл ажиллагааны үр дүнгээр илрүүлсэн байна.¹¹

Энэ нь цагдаагийн үйл ажиллагаа хэт “reactive” буюу гэмт хэргийн тухай гомдол, мэдээлэлд хариу өгөх хандлага давамгайлж байгаа бол харин олон улсын хууль сахиулах үйл ажиллагаанд “Proactive” буюу гэмт хэргийн шалтгаан, нөхцлийг илрүүлж арилгах, урьдчилан сэргийлэх цагдаагийн алба хаагчдын идэвхтэй хандлага ажиллагааг шаарддаг билээ.

4. Цагдаагийн байгууллагаын дотоод аюулгүй байдлыг хангах ажиллагааны туршлага судлах

Цагдаагийн байгууллагын барилга байгууламж, холбоо, харилцааны сүлжээ, автомашин, тусгай зориулалтын техник хэрэгсэлийг сайжруулахгүйгээр дэд бүтэц цагдаагийн байгууллага, алба хаагчийн аюулгүй байдлыг хангахад чухал нөлөөтэй.

Дэд бүтцийн хувьд цагдаагийн байгууллагад баримтлах олон улсын жишиг стандартыг баримталж буй туршлагыг харьцуулан судлах нь үйл ажиллагаандаа үнэлэлт өгөх гол нөхцөл болно.

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 153 дугаар “Цагдаагийн байгууллагын талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолоор цагдаагийн байгууллагын зарим үйлчилгээ, хангалтын жишиг норматив батлагдсан.

Цагдаагийн алба хаагчийн ажлын ачааллыг зүй зохистой байлгах, ажлын чанарыг сайжруулах, иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд Засгийн газрын 2011 оны 153 дугаар тогтоолд заасан нормативын дагуу улсын хэмжээнд орон тоог 3 417 алба хаагчаар нэмэгдүүлэх судалгаа гарч байна.

Хүний эрхийн комиссын судалгаанд хамрагдсан алба хаагчаас “Та өдөрт хэдэн цаг ажилладаг вэ?” гэсэн асуултад 5 хувь нь өдөрт 8 цаг хүртэл, 22 хувь нь 8-10 цаг, 33 хувь нь 10-12 цаг, 40 хувь нь 12 цагаас дээш хугацаагаар ажилладаг гэж хариулжээ. Үүнд шуурхай цугларалт, албаны бэлэн байдал, хүчлэн хамгаалалт зэрэг онцлог цаг үеэр ажиллуулсныг тооцоогүй болно.¹²

Цагдаагийн алба хаагчдын тогтвор суурьшилтай ажиллуулахын тулд ажлын ачааллыг олон улсын болон үндэсний жишиг норматив мөрдөж ажиллах шаардлагатай. Тухайлбал, мөрдөн байцаагчийн ажил дүгнэх үзүүлэлт, ажлын ачааллын олон улсын жишиг харьцуулалтыг судалгаа хийгдээгүй байна.

5. Цагдаагийн алба хаагчийн мэдлэг, боловсрол, мэргэжлийн ур чадвар, харилцааны соёлыг дээшлүүлэх сургах, дадлагжуулах

Гэмт хэрэг, зөрчилтэй үр нөлөөтэй тэмцэх нь цагдаагийн байгууллагын зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагаанаас гадна алба хаагчийн мэдлэг, мэргэшлийн ур чадвар, харилцааны соёлтой салшгүй холбоотой.

¹¹ Гэмт хэргийн статистик мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн ажлын тайлан, 2014 8 сар, ЦЕГ-ын МСТТ-ийн Судалгааны хэлтэс.

¹² Хүний эрхийн комиссын 14 дүгээр илтгэлээс 97 дахь тал

Гагцхүү үнэн бол шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын алба хаагчид тэр дундаа цагдаагийн алба хаагчийн эрхэлсэн алба ажил, мэргэшил нь өөрийнх нь зан төрхийг хэрхэн өөрчилснийг хэзээ ч анзаардаггүй явдал юм.

Жишээлбэл, цагдаагийн байгууллагыг шинэчлэхэд хамгийн түрүүнд ямар зүйлийг хийх вэ? гэсэн асуулгад оролцсон алба хаагчдын 30 хувь нь, иргэдийн 25 хувь нь харилцааны зөв боловсон байдал гэж дүгнэсэн байдаг.¹³

Цагдаагийн алба хаагч болон иргэдийн бодол санаа, хандлагыг өөрчлөх нь хамгийн хүнд бөгөөд их цаг хугацаа шаарддаг процесс юм.

Цагдаагийн хяналт үнэлгээний тогтолцоог хөгжүүлснээр цагдаагийн сургалтын зорилго, хэрэгцээ тодорхойлогдож гадаадад сургалтанд алба хаагчдыг өргөнөөр хамруулах, цагдаагийн алба хаагч, сургагч багш нарыг олон улсын цагдаагийн байгууллагад бэлтгэх, гадаад сургагч нарыг дотоодын сургалтанд оролцуулах нь зүйтэй.

Эцэст нь Монголын цагдаагийн байгууллагыг хүний эрхийг хамгаалах, хангахдаа олон улсын гэрээ, интерполын өмнө хүлээсэн цагдаагийн үүргийг тууштай биелүүлж, цагдаагийн байгууллагын түүхэн уламжлал, шинэчлэлийг хослуулан бодлого стратегиа төлөвлөж, эрх зүйн орчин, зохион байгуулалтын бүтцээ улам бүр боловсронгуй болгож, цагдаагийн үйл ажиллагааг олон улсын жишигт хүргэхэд олон улсын цагдаагийн байгууллагын хамтын ажиллагаа нэн чухал болохыг тэмдэглэж байна.

Дээр дурдагдсан саналуудыг “Хууль сахиулах байгууллага ба хамтын ажиллагаа” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлаас гарах зөвлөмжид тусгуулахыг хүсэж байна.

¹³“АРИГУМедиа” ХХК-ны ЦЕГ-ын ойрын /богино/ хугацааны “Олон нийттэй харилцах стратеги”-ийн төслийн судалгааны тайлан 2014 он